



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 0/199

Улаанбаатар хот

**Дүүргийн “Оролцоод хөгжье”
мэтгэлцээний аварга шалгаруулах
тэмцээн зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд иргэд, залуучуудын оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “Оролцоод хөгжье” мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах төсвийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 18 ны өдрийн
1114 дугаар захирамжийн хавсралт



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ПАРЛАМЕНТЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ
АВАРГА ШАЛГАРУУЛАХ “ОРОЛЦООД ХӨГЖЬЕ” ТЭМЦЭЭНИЙ
УДИРДАМЖ**

ЗОРИЛГО:

“Түншлэл-үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилтот жил”, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Оюунлаг Багахангайчууд” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, дүүргийн ард иргэд, олон нийтийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх, орон нутагт тулгарч буй асуудалд ул суурьтай хандах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөрийн бодлоо зөв цэгцтэй илэрхийлэх замаар багаар ажиллах, оюуны дархлааг нэмэгдүүлэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Багахангай дүүргийн Аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд, олон нийт

ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Багахангай дүүргийн зүүний хүчний холбоо

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Монголын мэтгэлцээний нэгдсэн танхим

ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ҮЕ ШАТ:

1. Парламентын мэтгэлцээний сургалт (Аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид, иргэд, олон нийт)
2. Парламентын мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээн

ХААНА, ХЭЗЭЭ:

Парламентын мэтгэлцээний сургалт 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 13.00 цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд

Парламентын мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 09.00 цагт дүүргийн Соёлын ордонд тус тус зохион байгуулагдана.

МЭТГЭЛЦЭХ ШИЙДЛҮҮД:

1. Манай дүүрэгт СУ-ийн салбар байх хэрэгтэй.
2. Зарим их дээд сургуулиудыг манай дүүрэгт авчрах нь үр ашигтай.
3. Нийслэлээс алс байрладаг нь сул тал биш.
4. Төмөр зам бол хөгжил хурдасгах цорын ганц арга мөн.
5. Том голын жижиг загас байснаас - Жижиг голын том загас байсан нь дээр

6. Хайран дээр суурилсан гэр бүлээс – Тооцоолол дээр суурилсан гэр бүл дээр
7. Боловсон хүчнийг нэмэгдүүлэх хамгийн гол арга нь орон сууцжуулалт мөн.
8. Дүүрэгт үйлдвэрүүд барих нь үр ашиггүй хөрөнгө оруулалт юм.
9. Хүн амын тоо цөөн байх нь улс орны хөгжилт шууд нөлөөлдөг.
10. Цахим орчинд гэмт хэргийн тухай мэдээлэл оруулахыг хориглох хэрэгтэй

ТЭМЦЭЭНИЙ ЖУРАМ:

1. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага бүр баг бүрдүүлж оролцоно (Жич: Хүн хүрэлцэхгүй байгууллагууд нэгдэж оролцож болно)
2. Баг тус бүр 2 гишүүнтэй байна.
3. Дүүрэгт ажиллаж амьдарч байгаа иргэд болон оюутан залууст нээлттэй.
4. Парламентын мэтгэлцээний үндсэн хугацаанаас 1 минутын хасалттай явагдана.
5. Парламентын мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээнд оролцох багийн мэдүүлгийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 17.00 цагийн дотор ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэст ирүүлнэ
6. Хагас шигшээд шалгарсан багууд хасагдах зарчмаар мэтгэлцэнэ.

Шагнал урамшуулал:

- I байр Өргөмжлөл, (300,000) мөнгөн шагнал
II байр Өргөмжлөл, (200,000) мөнгөн шагнал
III байр Өргөмжлөл, (100,000) мөнгөн шагнал